



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 3/23

Хэрлэн сум

Д.Наранцацралыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.3, 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоолын хавсралт, Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн батлах тухай” 241 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, “Сангийн сайд, санхүүгийн зохицуулах хорооны даргын 2006 оны 392/90 дугаар хамтарсан тушаал”-ын 2 дахь заалт, Санхүү, эдийн засгийн сайдын 2022 оны 258 дугаар тушаалаар баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам”-ын 2.1, Засгийн газрын 2022 оны “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 489 дүгээр тогтоол, Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн 04 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны Арваннаймдугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дашдондогийн Наранцацрал нь төрийн албаны тусгай шалгалтад тэнцсэн тул 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Санхүү, төрийн сангийн хэлтсийн Бүртгэлийн мэргэжилтний албан тушаалд томилсугай.

2. Д.Наранцацралын ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын  
дарга:

С.Нямдаваа

Санхүү, төрийн сангийн хэлтсийн  
дарга

Гишүүд:

Д.Цэцэгсүрэн

Аймгийн төсвийн ерөнхийлөн

2.

захирагчийн төсвийн ерөнхий  
Нягтлан бодогч

Х.Баярбаатар Төсвийн орлого хариуцсан  
мэргэжилтэн

Д.Энхтуяа Архив, Бичиг хэргийн эрхлэгч

С.Чулуунцэцэг Нярав

3.Д.Наранцацралын цалинг ТЗ-7 зэрэглэлээр тогтоож, үндсэн цалинг 1,320,000 (нэг сая гурван зуун хорин мянган) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 17 хувиар, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40 хувиар, Санхүүгийн зохицуулах хорооны орон нутгийн төлөөлөгчийн ажлыг хавсран ажил гүйцэтгүүлэх нэмэгдлийг 20 хувиар, мэргэшсэн нягтлан бодогчийн мэргэшлийн зургийн нэмэгдлийг 15 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч (Х.Баярбаатар)-д үүрэг болгосугай.

4.Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, тогтоолын шийдвэр, байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Д.Наранцацралд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА